



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/81

Шивээговь сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 2-оос доошгүй жил дараалан газраа ашиглаагүй иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн газарт хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Гантуяа

(Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд:

Д.Маналмаа

(2-р багийн Засаг дарга)

С.Отгонбаатар

(1-р багийн Засаг даргын

үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Д.Мөнхзаяа

(Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:


Т.Өлзийбуд

(Газрын даамал)

2. Хяналт шалгалтын ажлыг чанартай зохион байгуулж баримт нотолгоог бүрдүүлэн газраа ашиглаагүй тухай тайлан мэдээг нэгтгэн тайлагнахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Т.Өлзийбуд)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ